

ТӨСЛИЙН ДУГААР 2024/ 14

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: "Байшинт-Ойл" ХХК, РД: 3675122, Сүхбаатар аймаг, Уулбаян сум, 2 дугаар баг

Төслийн нэр: "Шатахуун түгээх станц" шатах, тослох материал худалдан борлуулах

Холбоо барих утас, И-мэйл хаяг: Утас: 99077619, gombosurenchimgee@gmail.com

Төслийн товч тодорхойлолт: Байшинт-Ойл ШТС нь "нефтийн бүтээгдэхүүн, тос тосолгооны материал" - аар үйлчлэх ээлжийн 3 ажилтантай.

Шатахуун түгээх станц нь РГС-25 маркийн хэвтээ цилиндр резервуар 3 ш, амьсгалах клапан СМДК маркийн 3 ширхэг, шатахуун тээврийн хэрэгслээс ШТС-ын нөөцлүүр саванд шатахууныг буулгах үед савнаас түрэгдэн гарах уурыг шатахуун тээврийн хэрэгслийн торх руу дамжуулах зориулалтын хоолойгоор тоногдсон буулгах байгууламжтай, төвийн цахилгаанд холбогдсон бөгөөд шугамыг техникийн нөхцөлийн дагуу хийгдсэн.

	Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд	Нийцсэн	Нийцээгүй	Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай	Үндэслэл тайлбар
Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт	Тийм			
Төрийн бодлого шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн заалт	Тийм			
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутагт байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м)	Тийм			
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг мэдрэмтгий эсэх	Тийм			
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр	Тийм			

	орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх				
	Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсэх эсэх	Тийм			
	Агаарын чанар				
	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх		Тийм		
	Дуу чимээ, доргио чичэргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх		Тийм		
	Усан орчин				
	Гадаргын болон газрын доорхи усны нөөцийн хомсдол үүсэх эсэх	Тийм			
	Цэнгэг усны нөөцийг ашиглах эсэх	Тийм			
	Гадаргын болон газрын доорхи усанд бохирдол үүсэх эсэх		Тийм		
	Хөрсөн бүрхэвч				
	Хөрсөн бүрхэвч эвдрэх эсэх		Тийм		
	Хөрс бохирдуулах эсэх		Тийм		
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Хөрс доройтох цөлжих эсэх		Тийм		
	Ургамалан нөмрөг				
	Ургамалан нөмрөг, ой мод өртөх эсэх		тийм		
	Ховор, нэн ховор ургамалын төрөл зүйлс өртөх эсэх	Тийм			
	Амьтны аймаг				
	Зэрлэг амьтадын амьдрах орчинг доройтуулах эсэх	Тийм			
	Ховор, нэн ховор амьтан өртөх эсэх	Тийм			
	Нутгийн оршин суугчид				
	Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх эсэх	Тийм			
	Нутгийн оршин суугчдын нийгмийн		Тийм		

байдалд сөрөг нөлөөлтэй эсэх				
Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа эсэх		Тийм		
Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх эсэх	Тийм			
Түүх, соёлын биет өв				
Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх	Тийм			
Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл				
Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх		Тийм		
Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх		Тийм		

Нэгдсэн дүгнэлт: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.2 дахь заалтын дагуу төслийг тодорхой НӨХЦӨЛ БОЛЗОЛТОЙ- оор хэрэгжүүлэх боломжтой гэж үзэв.

Онцгойлон анхаарах зүйлс:


1. Төслийн үйл ажиллагаа болон ахуйн хэрэглээнээс гарах хатуу шингэн /аюултай/ хог хаягдлыг байгаль орчин, хүний эрүүл мэндэд халгүй аргаар цуглуулах, хуримтлуулах, эх үүсвэр дээр нь ангилан ялгах, Засаг даргын Тамгын газартай гэрээ байуулан ажиллах.
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон ажлын байран дахь гэрэлтүүлэгийг зөвшөөрөх хэмжээнд тавих ерөнхий шаардлага MNS6767:2019, Тээврийн хэрэгсэлд тавигдах техникийн шаардлага MNS4598:2011 бусад шаардлагатай стандартуудыг чанд баримтлан ажиллах.
3. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад байгалийн гамшиг болон хүний буруугаас үүдэн гарч болзошгүй ослын үнэлгээхийж, тэдгээрээс сэргийлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх
4. Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3. дахь заалт, БОАЖС-ын 2019.10.29-ы өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 1.3. дахь заалтын дагуу тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр боловсруулж, хянуулж, батлуулан, дүгнүүлэн ажиллах.
5. Барилга хот байгуулалтын сайдын 2014 оны 57 дугаар тушаалаар баталсан "Шатахуун түгээх станц, Галын аюулгүй норм" –ийг баримтлан аюулгүй ажиллагааг ханган ажиллах.
6. Галын аюулгүй байдлын дүгнэлтийг жил бүр Онцгой байдлын газраас

гаргуулах.

7. Ил задгай хог хаягдал хаяхгүй байх мөн MNS5924:2015 стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар иргэдэд нээлттэй үйлчлэх
8. Хөрс, ус, агаараас дээж авах цэгийг стандартын дагуу тогтоож, шинжилгээнд тогтмол хамруулж үр дүнг тайланд хавсаргах.
9. Төсөл хэрэгжих газар нутгийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлыг харуулсан фото зураг бусад шаардлагатай барилга байгууламжийн мэдээлэлүүд болон схем зураг хийлгэж байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хавсаргах.
10. Автотээврийн хэрэгсэлийн шатдаг хийгээр цэнэглэх станц. Техникийн ерөнхий шаардлага MNS5676:2006 стандартыг мөрдөх.
11. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны А-230-127 дугаартай хамтарсан тушаалаар батлагдсан "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэм"-ийг мөрдөх.
12. Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээ 2019 оны 11 сарын 11-ны №02231-2019/00020 тоот гэрээнд тусгагдсан Газар эзэмшигчийн үүргийг биелүүлж ажиллах.
13. Эрх бүхий албан тушаалтанаас тавьсан хууль ёсны албан шаардлагыг биелүүлэх

ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА, ШИНЖЭЭЧ



Ш.НЯМХҮҮ

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН:

БАЙШИНТ-ОЙЛ ХХК УУЛБАЯН
СУМАН ДАХ ШТС-ЫН ЭРХЛЭГЧ

Г.ЧИМГЭЭ

2024.04.24

ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

АЛБАН ТУШААЛ: УСНЫ НӨӨЦИЙН
АШИГЛАЛТ, ХАМГААЛАЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

П.БОЛОРТУНГАЛАГ
2024.04.24